



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 29 өдөр

Дугаар А/26

Мөрөн сум

Хөрөнгө шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1.12, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.9, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 88 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд үндсэн хөрөнгө төлөвлөх, олж авах, бүртгэх, худалдах, шилжүүлэх, актлах журам”-ын 6.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн өмчит хуулийн этгээд Мөрөн сумын Засаг даргын Тамгын газрын эзэмшилд байгаа 53,585,250 (Тавин гурван сая таван зуун наян таван мянга хоёр зуун тавь) төгрөгийн балансын анхны өртөгтэй 2013 онд ашиглалтад орсон хог цэвэрлэгээний Forland маркын 2811 ХӨВ улсын дугаартай автомашиныг аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Орон нутгийн өмчийн газар, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга, захирал нарт дор дурьдсан арга хэмжээг авч ажиллахыг үүрэг болгосугай.

2.1 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэлд тусгах;

3. Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга (Ц.Бэхбаяр)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ПҮРЭВДОРЖ